

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ
ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ 2025 ОНД ТӨЛӨӨЛӨН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2025.06.05

Чингис хот

№	Заалт	Хэрэгжилт
1.1	Биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдагчдыг 2 хувиар нэмэгдүүлж, залуучуудын оролцоог хангах	2025 оны эхний хагас жилийн байдлаар биеийн тамир, спортын арга хэмжээнд аймгийн хэмжээнд хамрагдагчдын тоо 18922 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 19%-иар нэмэгдсэн байна.
1.2	Спортын тамирчдыг 2%-иар өсгөх	Спортоор хичээллэгчдийн тоо 4200 байгаа нь өмнөх оноос 0,7%-иар өссөн байна.
1.3	Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил хамрагдагчдыг 3%-иар нэмэгдүүлэх	Бие бялдрын түвшин тогтоох сорилын аяныг 2025 оны 04 дүгээр сарын 01-нээс 5 дугаар сарын 20-ний өдрийн хооронд аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж сумд болон албан байгууллага, аж ахуй нэгж сургууль цэцэрлэгүүдэд албан тоот хүргүүлэн , сорилын баг гарган ажиллаж арга зүйн зөвөлгөө мэдээ мэдээлэл сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр олон нийтэд сурталчилж, Сорилын баг албан байгууллагуудаар ажиллаж 2025 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 4472 иргэн хамрагдсанаас 3316 иргэн буюу 74% нь А,В,С үнэлэгдсэн байна.
1.4	Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил хамрагдагчдаас А, В, С үнэлгээтэй хүнийг 1%-иар нэмэгдүүлэх	2025 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 4472 иргэн хамрагдсанаас 3316 иргэн буюу 74% нь А,В,С үнэлэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 2%-иар өссөн байна.
1.5	Сумын биеийн тамирын арга зүйчийн тоо	Дадал, Баян-Адарга, Батширээт, Норовлин, Баянмөнх, Батноров сумдад ажиллаж байгаа биеийн тамирын арга зүйчийн тоо 6 байна.
1.6	Өсвөрийн шигшээ багийн спортын 10 төрлөөр байгуулах	Аймгийн Засаг даргын дэргэдэх Өсвөр үеийн шигшээ баг 2025 онд шигшээ багийн 14 спортын төрөлд 320 тамирчид сургалт-дасгалжуулалтад хамрагдан үйл ажиллагаа явуулж байна. Өсвөрийн шигшээ багийн тамирчид 19 удаагийн олон улс, улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд нийт 399 тамирчин оролцож 32 алт, 32 мөнгө, 39 хүрэл медаль нийт 103 багц медаль хүртсэн амжилт үзүүллээ.
1.7	Тухайн орон нутагт дэлгэрээгүй спортын төрлийг шинээр хөгжүүлэх	Тийболын спортын төрлийг орон нутагт шинэ тутамд хөгжүүлэхээр тус спортын багш дасгалжуулагч бэлтгэх сургалтанд 2 хүн хамруулан ажиллаа.
1.8	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийн биеийн тамир, спортын үйлчилгээний цэгийг нэмэгдүүлэх	2025 эхний хагас жилийн байдлаар өглөөний дасгалын "Мөнхийн хайрын урсгал" , нийтийн бүжгийн Туяа, Заяа, шугаман болон нийтийн бүжгийн холбоо, клуб, ХААН дартс датрын холбоо гэсэн нийт 5-н холбоо клубтай нийтийн биеийн тамирын чиглэлээр хамтран ажиллаж биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна .
1.9	Орон нутгийн онцлогт нийцүүлэн Үндэсний спортыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх	Орон нутгийн онцлогт нийцүүлэн Үндэсний спортыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэхээр үндэсний бөх, үндэсний сурын төрлүүдийг аймгийн томоохон евэнт арга хэмжээнд тогтмол оролцуулж байна.

ХЭНТИЙ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР